



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 8/446

Арвайхээр

### Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 13 дугаар баг Д.Пүрэвдоржийн 1 дүгээр гудамж 107 тоотод байрлах Өвөрхангай аймгийн Цагдаагийн газрын (9045023) эзэмшил төрийн захиргааны байгууллагын зориулалттай 4477 мкв газрыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт (3555739) зориулалтын дагуу 30 жил 7 сарын хугацаатайгаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 168 дугаар захирамжийн Өвөрхангай аймгийн Цагдаагийн газартай холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100991